


Иргэн Та сонгогчдын нэрийн жагсаалтанд бүртгэгдсэн эсэхээ шалгана уу.

Регистрийн дугаар

Доорх зурган кодыг оруулна



ШАЛГАХ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛЬ 2020

СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТАД ХИЙСЭН МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН

МОНИТОРИНГИЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол Улс ардчилалд шилжсэн цагаас хойш төрийн эрх барих дээд байгууллага Улсын Их Хурал (УИХ)-ыг бүх нийтийн чөлөөт сонгуулиар найман удаа сонгож бүрдүүлжээ. Үүнээс сонгуулийн үр дүнг эсэргүүцсэн үймээнээр төгссөн 2008 оны сонгууль манай ардчиллын түүхнээ гашуун сургамж болж үлдсэн. Энэ сонгуулиас сургамж авч сонгогчдын нэрийн жагсаалт болон санал тоолох үйл явцыг автоматжуулах эрх зүйн орчныг 2011 онд бүрдүүлж, улмаар 2012 оны УИХ-ын сонгуулиас эхлэн өнөөг хүртэл хэрэгжүүлж ирлээ. Гэвч санал тоолох автомат төхөөрөмж болон сонгогчдын нэрийн жагсаалтад үл итгэх байдал ажиглагдсан хэвээр байна. Ялангуяа, сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой санал, гомдол 2016 оны УИХ-ын сонгуулиас хойш нэлээд гарах болсон. Тухайлбал, 2016 оны УИХ-ын сонгуулийн үеэр Сонгогчдын боловсрол төвийн ажиллуулсан сонгогчдод зөвлөгөө өгөх лавлах утсанд ирсэн гомдол,

саналын 45 хувь нь сонгогчийн хаягт илүү сонгогч бүртгэгдсэн тухай, 22 хувь нь дутуу бүртгэгдсэн тухай, 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн 24 хувь нь мөн ийм дуудлага, 50 орчим хувь нь сонгогчийн бүртгэлийн хуудастай холбоотой байсан талаар тус байгууллагаас мэдээлж байв.

Сонгуулийн үйл явцад итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэхэд сонгуулийн үйл явц ил тод, бүх тал хяналт тавих боломжтой байх нь туйлын чухал юм. Үүнд бие даасан иргэний нийгмийн байгууллагуудын хяналт чухал бөгөөд МИДАС ТББ-ын зүгээс 2020 оны УИХ-ын сонгуулийн явцад санал тоолох төхөөрөмжийг сонгуульд бэлтгэх үйл явц болон сонгогчдын нэрийн жагсаалтад хяналт тавих ажлыг 2020.05.01 – 2020.06.30-ны хооронд зохион байгуулж гүйцэтгэлээ. Энэхүү тайланд сонгогчдын нэрийн жагсаалтад хийсэн мониторингийн үр дүнг танилцуулж байна.



ЗОРИЛГО, ЗОРИЛТ

- Сонгогчдын нэрийн жагсаалтыг тодорхой хүрээнд шалгаж нягтлах, уг жагсаалттай холбоотой гарч буй хүндрэл, саад бэрхшээлийг тодорхойлох;
- Сонгогчдын нэрийн жагсаалт, сонгогч шилжихтэй холбоотой зохицуулалт, хэрэгжилтийг сайжруулах санал зөвлөмж боловсруулах.

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын УИХ-ын сонгуулийн тухай хуулийн “Сонгуулийн ажиллагааг автоматжуулах” тухай 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “сонгуулийн үйл ажиллагааг автоматжуулахтай холбогдсон харилцааг Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулиар зохицуулна” гэж заасан. УИХ-аас 2011 онд баталсан Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 4.1.1-д “сонгуулийн автоматжуулсан систем” гэж сонгуульд бэлтгэж, түүнийг хуулийн дагуу зохион байгуулахад ашиглах зориулалттай мэдээллийн санг бүрдүүлж, сонгогчийн хувийн мэдээлэлтэй тулган нягтлах, сонгогчдын саналыг авах, авсан саналыг тоолох, сонгуулийн дүнг нэгтгэн хадгалах, дамжуулах, баримтжуулах ажиллагааг автоматжуулах үүрэг бүхий цахим мэдээллийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, программ хангамж, тэдгээрийг ажиллуулах хүний нөөц, санхүүгийн эх үүсвэрийн харилцан уялдаа бүхий цогц”-ыг ойлгоно гэж заажээ. Тодруулбал, сонгуулийн автоматжуулсан систем нь сонгогчдын бүртгэл, санал тоолох систем гэсэн хоёр тусдаа хэсгээс бүрдэж байна.

УИХ-ын сонгуулийн тухай хуульд “Сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэний улсын бүртгэлийн

цахим мэдээллийн санд үндэслэн үйлдэх бөгөөд түүнийг нягтлан шалгах, давхардлыг арилгах, сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй сонгуулийн эрх бүхий иргэнийг бүртгэх, эдгээртэй холбоотой гомдлыг шийдвэрлэх ажлыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангана” (21-р зүйл, 21.1 дэх хэсэг) гэж заасан. Улсын бүртгэлийн ерөнхий газар 2012 оны УИХ-ын сонгуулиас эхлэн сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэх болон холбогдох бусад үүргийг хариуцан ажиллаж ирлээ. Үүнд сонгогчийг бүртгэх, түүнийг таньж оруулах техник хэрэгсэл, сэлбэг, программ хангамж худалдан авах, түрээслэх, ашиглах, хадгалах, хамгаалах, засвар үйлчилгээг хийх, сонгогчийн нэрийн жагсаалт үйлдэх, түүнийг цахим хуудаст байршуулах, хэвлэх, хүргэх, мэдээлэл, сурталчилгаа явуулах, улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн болон гэрээт ажилтны сургалт зохион байгуулах, сонгогчийг бүртгэх техник хэрэгслийн аюулгүй байдлыг хангах, техник тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах зэрэг ажлыг хариуцан зохион байгуулдаг.



СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТЫН ХУВЬД АНХААРАЛ ТАТАХ ДАРААХ ЗОХИЦУУЛАЛТЫГ ОНЦОЛЖ БАЙНА. ҮҮНД:

Сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэх, ил тод байдлыг хангахтай холбоотой

- | | |
|---|--|
| <p>1. 20.14. Сонгогчдын нэрийн жагсаалт цаасан болон цахим хэлбэртэй байх бөгөөд сонгогчийг сонгуулийн зөвхөн нэг хэсэгт бүртгэнэ.</p> <p>20.4. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сонгогчдын нэрийн жагсаалтад байгаа сонгуулийн эрх бүхий иргэний эцэг (эх)-ийн болон өөрийн нэр, нас, хүйс, регистрийн дугаар, байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн мэдээллийг аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороогоор болон хэсэг нэг бүрээр нэгтгэн гаргах бөгөөд уг жагсаалтыг ээлжит сонгуулийн жилийн 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхэлж, сонгууль дуустал өөрийн цахим хуудсанд байршуулна.</p> <p>20.5. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сонгогчийг энэ хуулийн 20.4-т заасан цахим хуудсанд байршуулсан сонгогчдын нэрийн жагсаалтаас өөрт нь холбогдох мэдээлэлтэй танилцах боломжоор хангана.</p> <p>20.10. Хэсгийн хороо сонгогчдын нэрийн жагсаалтыг хүлээн авсан өдрөөс эхлэн өөрийн ажиллах байранд, өөрийн ажиллах байргүй бол сум, хорооны засаг даргын тамгын газрын байранд сонгогч өөрт нь холбогдох мэдээлэлтэй чөлөөтэй танилцах боломж олгоно.</p> | <p>Нэг сонгогч - нэг санал өгөх зарчим нь тэгш сонгуулийн чухал зарчим бөгөөд үүнийг хангахын тулд нэг сонгогч зөвхөн нэг хэсэгт бүртгэлтэй байх буюу сонгогчдын нэрийн жагсаалтад сонгогчийг давхар бүртгэхгүй байх шаардлагыг хуулийн энэ хэсэгт тусгасан.</p> <p>Сонгогчдын нэрийн жагсаалт үнэн зөв эсэхийг магадлахын тулд олон талын хяналт чухал билээ. Хуульд заасны дагуу нэрийн жагсаалтыг burtgel.gov.mn сайтад байрлуулдаг хэдий ч энэ сайт руу тэр бүр олон сонгогч орж бүртгэлийн мэдээллээ шалгадаггүй (5000 гаруйхан хүн – УБЕГ-ын төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас) байна.</p> <p>Сонгогчдын нэрийн жагсаалтыг нэгдсэн бааз үүсгэн үйлдэж давхардлыг шалгаж байгаа хэдий ч нэг хүнийг өөр өөр регистрээр давхар бүртгэсэн байх болзошгүй тохиолдлыг мэдээллийн баазаас шууд шалгах боломж тун тааруу болно.</p> <p>(2016 оны УИХ-ын сонгуулийн үеэр ийм нэг тохиолдлыг баримтжуулсныг хавсралтаас үзнэ үү.)</p> |
|---|--|

Сонгогчийн нэрийн жагсаалттай холбоотой гомдлыг шийдвэрлэх, зохих өөрчлөлтийг оруулах, түүнд хяналт тавихтай холбоотой

- | | |
|--|---|
| <p>2 20.11. Сонгогч сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэхээ санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө шалгасан байвал зохино.</p> <p>23.1. Сонгогч сонгогчдын нэрийн жагсаалт дахь өөрийн болон гэр бүлийн гишүүний мэдээлэлтэй танилцах эрхтэй бөгөөд сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй, эсхүл буруу бүртгэгдсэн бол өөрийн болон гэр бүлийн гишүүний нэрийн өмнөөс гомдлоо улсын бүртгэлийн байгууллагад санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө бичгээр гаргана.</p> | <p>Сонгогчдын зүгээс өөрийнх нь амьдардаг хаяг дээр хамт амьдардаггүй буюу байнга оршин суудаггүй¹ хүмүүс бүртгэсэн талаар гомдол сүүлийн сонгуулиудаар тасралтгүй гарч сонгогчдын нэрийн жагсаалтын үнэн зөв байдалд эргэлзээ үүсэхэд нөлөөлж байна. Үүнийг шийдвэрлэхийн тулд өөрийн хаяг дээр бүртгэлтэй байгаа хүмүүсийн мэдээлэлтэй сонгогч аль болох эрт танилцаж зохих газар гомдол гарган шийдвэрлүүлэх боломжоор хангах явдал мөн боловч УБЕГ-ын цахим хуудсанд ил болгож буй сонгогчдын нэрийн жагсаалтаас ийнхүү шалгах боломж байхгүй.</p> |
| <p>5. 23.2. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санг үндэслэн энэ хуулийн 23.1-д заасны дагуу гомдол гаргасан иргэний мэдээллийн талаар лавлагаа гаргах ба сонгогчийн мэдээлэлтэй холбогдсон өөрчлөлтийг санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө сонгогчдын нэрийн жагсаалтад оруулна.</p> | <p>Энэ нөхцөлд сонгогчийн зүгээс зөвхөн өөрийн бүртгэлийг нягтлан сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй, эсхүл буруу бүртгэгдсэн талаар гомдол гаргахаас өөр агуулгатай гомдол гаргаж шийдвэрлүүлэх боломж байхгүй байна.</p> <p>Сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах үндэслэлд тухайн хаяг дээр байнга оршин суудаггүй сонгогчийг бүртгэсэн нөхцөлийг тусгаагүй байгааг анхаарвал зохино.</p> |
| <p>6. 23.3. Энэ хуульд зааснаас бусад үндэслэлээр сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг хориглоно.</p> | |

¹ Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1. дэх хэсэгт “Иргэн иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлтэй хаягаас өөр хаягт шилжин 180 хоногоос дээш хугацаагаар оршин суухаар бүртгүүлэхийг байнга [...] оршин суух гэнэ” гэж тогтоожээ.



Ажиглагч сонгогчийн нэрийн жагсаалтад хяналт тавихтай холбоотой зохицуулалт

7. 23.5. Ажиглагч нь сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах талаар энэ хуульд заасан хугацаа дууссанаас хойш сонгогчдын нэрийн жагсаалт болон түүнд оруулсан өөрчлөлттэй танилцах эрхтэй.	УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 20.13 дахь хэсэгт заасны дагуу нам, эвсэл нь сонгууль болохоос 20 хоногийн өмнө сонгогчдын нэрийн жагсаалтын сонгогчдын эцэг (эх)-ийн болон өөрийн нэр, регистрийн дугаар, байнга оршин суугаа газрын хаяг бүхий хэсгийг хүсэлт гарган авч хянах боломжтой байдаг. Энэ удаагийн сонгуулиар CD-гээс хуулах, хайлт хийх боломжгүй байдлаар өгсөн нь сонгогчдын нэрийн жагсаалтаас түүвэрчлэн шалгахад хүндрэл учруулсныг дурдах нь зүйтэй.
8. 23.6. Ажиглагч энэ хуулийн 23.5-д заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалттай танилцахдаа зураг авах, бичлэг хийх зэргээр сонгогчдын нэрийн жагсаалтыг хувилж, олшруулахыг хориглоно.	Өнгөрсөн хугацаанд намуудын зүгээс иргэний нийгмийн ажиглагчдын адил өргөн хүрээнд тодорхой аргачлалын дагуу сонгогчдын нэрийн жагсаалтад хяналт тавьсан удаа байхгүй. Харин иргэний нийгмийн ажиглагчдын хувьд сонгогчдын нэрийн жагсаалтын хуулбарыг авах боломжгүй байгаа нь хяналт тавих бололцоог боомилж байна.
9. 23.7. Энэ хуулийн 23.5-д заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалтыг танилцуулах үйл ажиллагааг итгэмжлэгдсэн ажилтан болон хэсгийн хорооны дарга хамтран зохион байгуулж, хяналт тавина.	

Сонгогчдын шилжих хөдөлгөөнтэй холбоотой зохицуулалт

10 24.1. Сонгуулийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтан, мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, санал авах байр болон сонгуулийн үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах ажиллаж байгаа цагдаагийн албан хаагчийн сонгогчийн шилжилтийг хийх, бүртгэхдээ тухайн байгууллагынх нь албан бичгийг үндэслэн санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө шийдвэрлэнэ.	“Түр хасав”, шилжилт хөдөлгөөний тайланг нам, эвсэл, ТББ-ын ажиглагчдад хянах боломж олгохгүй байна. Түүнчлэн, 2015 оны УИХ-ын сонгуулийн хуулиар сонгогчийн шилжих хөдөлгөөн хийх боломжийг хаасан нь сонгууль бүх нийтийн байх зарчмыг хангах, сонгогч эрхээ хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулж болзошгүй нөхцөл үүсгэж байна.
11 24.2. Нэр дэвшигч болон энэ хуулийн 37.3-т заасан менежер, шадар туслагч нь сонгуулийн нэг хэсгээс нөгөө хэсэгт шилжих бол санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө сонгогчийн шилжилтийг хийлгэж болно.	
12 24.3. Энэ хуулийн 24.1, 24.2-т заасан сонгогч санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө сонгогчийн шилжилтийг бүртгүүлнэ.	

СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТАД ХЯНАЛТ ТАВЬСАН АРГАЧЛАЛ

Сонгогчдын нэрийн жагсаалтад хяналт тавихад хамгийн олон иргэн оршин суудаг, тэр дундаа орон нутгаас шилжин суурьшсан иргэд олноор оршин суудаг дүүргүүдийг хамруулах нь зүйтэй гэж үзэн Сонгинохайрхан, Баянзүрх дүүргүүдийг сонгосон ба сонгуулийн хэсэг, хороодыг сонгохдоо дараах шалгуурыг баримтлав. Үүнд:

- Тухайн дүүрэгт 2 сонгуулийн тойрог хиллэж байгаа хороодыг сонгох (хооронд нь харьцуулах үүднээс)
- Алслагдмал хороод, тус хороонд байгуулагдсан бүх сонгуулийн хэсгийн хороог сонгох (задгай гэсэн хаяг дээр

олноор бүртгэгдсэн иргэдийн мэдээллийг шалгах зорилгоор)

Сонгогчдын нэрийн жагсаалтаас хяналт тавих хаягийг түүвэрлэхдээ дараах аргачлалыг баримтлав. Үүнд:

- Нэг хаяг дээр олон хүн (6-аас дээш) бүртгэлтэй байгаа эсэх;
- Ижил овог, ижил нэртэй хүн нэг хаяг дээр бичигдсэн эсэх;
- Овог өөр, нэр ижил, регистрийн дугаар ижил, эсвэл ойролцоо хүмүүс ойролцоо хаяг дээр амьдарч байгаа эсэх;



- Овог, нэр өөр олон хүмүүс нэг хаяг дээр байгаа эсэх (холбоо хамааралгүй хүмүүс);
- Түр хасав төлөвийн тоо нэг хаяг дээр олон байгаа эсэх;
- Хувь хүн болон намуудаас сэжигтэй гэж үзэж нийтэд мэдээлсэн болон манай байгууллагад хандсан тохиолдлуудыг шалгах.

Сонгогчийн нэрийн жагсаалтаас дээрх тохиолдлуудыг шүүн хаяг, овог нэр, насыг нь тэмдэглэж авах ба тэмдэглэсэн мэдээллийн дагуу хаягаар нь очиж баталгаажуулах зарчмаар ажиллав. Ингэхдээ:

- Бүртгэлтэй сонгогчид бүгд хаяг дээрээ байгаа эсэх;
- Байнга оршин суудаг иргэдийн мэдээлэл;
- Бүртгэлтэй хэдий ч өөр газар оршин суудаг иргэдийн мэдээлэл;
- Өөр газар амьдардаг ч бүртгэлтэй хүмүүсийг тухайн хаяг дээр одоо амьдарч байгаа хүмүүс таних эсэх;
- Хашаа, байрандаа анхнаасаа оршин суусан эсэхийг урьдчилан бэлтгэсэн хүснэгтэд тэмдэглэн тухай бүр баримтжуулах арга хэмжээ авав.

Хэрэв сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэлтэй хаягаар очих үед эзгүй байвал хөрш айлуудаас нь тухайн хаягт амьдарч буй иргэдийн мэдээллийг тодруулах, аргачлалд тусгасан нягтлах шаардлагатай мэдээллийг бүрэн авч чадаагүй бол оршин суугчдыг гэртээ ирэх үед дахин очиж мэдээллийг баталгаажуулах удирдамжийг мөрдлөг болгосон болно. Түүнчлэн хаягийг хайгаад олохгүй байх, тодорхой хаяг дээр бүртгэлтэй ч амьдардаггүй иргэдийн мэдээллийг дээр дурдсан аргаар тодруулах бололцоогүй нөхцөлд хэсгийн ахлагч нараас туслалцаа хүсэн шаардлагатай мэдээллийг авах байдлаар ажиллав.

Дээр дурдсанчлан УИХ-ын сонгуулийн тухай хуулийн дагуу сонгогчдын нэрийн жагсаалтын хуулбарыг нам, эвслийг төлөөлөх эрх бүхий этгээдийн хүсэлтийн дагуу санал авах өдрөөс 20-иос доошгүй хоногийн өмнө цахим хэлбэрээр нэг удаа олгодог. Сонгуулийг ажиглан хяналт тавьж ажиллаж буй иргэний нийгмийн байгууллагуудын хувьд хуулбарыг авах боломжгүй тул мониторингийн багийн зүгээс сонгогчдын нэрийн жагсаалтад хөндлөнгийн хяналт хийхдээ доорх улс төрийн нам, эвслүүдийн Төв байр болон Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдийн штабуудад 2020 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн №24 дугаар албан бичгээр хамтран ажиллах санал хүргүүлсэн.

Үүнд:

Монгол Ардын Нам (МАН)
 Ардчилсан Нам (АН)
 Монголын Ногоон Нам (МНН)
 Та Бидний Эвсэл
 Шинэ Эвсэл
 Зөв Хүн Электорат (ХҮН)
 Хөдөлмөрийн Үндэсний Нам
 Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч Нам
 Хөгжлийн Хөтөлбөрийн Нам
 Эх Орончдын Нэгдсэн Нам (ЭОНН)
 Зон Олны Нам (ЗОН)
 Ард Түмний Олонхийн Засаглал Нам (АТОЗН)
 Их Эв Нам (ИЭН)
 Гэр Хороолол Хөгжлийн Нам (ГХХН)

Албан бичигт сонгогчдын нэрийн жагсаалтад тодорхой нэг хаяг дээр олон сонгогч бүртгэгдсэн нь эргэлзээ төрүүлж буй мэдээлэл, мөн нэг хаяг дээр ижил овог, нэр бүхий, нас ойролцоо сонгогчид бүртгэсэн тохиолдлууд, 2019 оны 12 дугаар сарын 25-аас 2 дугаар сарын 1-ний хооронд шилжин ирсэн сонгогчид болон “түр хасав” төлөвтэй бүртгэгдсэн байгаа сонгогчдын мэдээллийг шүүн, шаардлагатай гэж үзвэл нягтлан шалгах боломж олгон мониторингийн багт ирүүлэхийг хүссэн.



Дээрх хүсэлтийн дагуу Монгол Ардын Намаас Сүхбаатар дүүргийн 9, 12, 13 дугаар хорооны нийт 10 хаяг шалгуулахаар мэдээлэл ирүүлсэн юм.

Нам, эвслийн хувьд CD дээр хүлээн авсан Сонгогчдын нэрийн жагсаалт нь зөвхөн нэг хувь учир тойрогт нэр дэвшигчдэд хүрэлцэхгүй, мөн өгөгдөл дээр овог нэр, хаяг, регистрийн

дугаар, эсвэл насаар нь ангилах боломжгүй учир шалгахад цаг хугацаа их шаардан хяналт тавихад хүндрэл учруулж байсныг энэ дашрамд дурдах нь зүйтэй.


Зарим нам, эвслийн хувьд сонгогчдын нэрийн жагсаалтын хуулбарыг авах боломжтой талаар хуулийн мэдлэг, мэдээлэл дутмаг байв.

МОНИТОРИНГИЙН ДҮН

Мониторингийн багийн зүгээс Сонгинохайрхан, Баянзүрх дүүргүүдийн сонгуулийн тойргуудын хил залгаа байрлалтай хороодыг сонгон авч, тухайн хороонд байгуулагдсан бүх сонгуулийн хэсгийн хороодын сонгогчдын нэрийн жагсаалттай танилцах зорилт тавьсан. Дүүргүүдийн сонгуулийн хороонд “Сонгогчдын нэрийн жагсаалтад хөндлөнгийн хяналт хийхэд дэмжлэг үзүүлэх тухай” №28 дугаар албан бичиг, хавсралтад Сонгуулийн Ерөнхий Хорооноос

гаргасан “Сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт, хөндлөнгийн хяналт хийх төрийн бус байгууллагуудыг бүртгэх тухай” 2020 оны 6 дугаар сарын 1-ний өдрийн №199 дүгээр тогтоол, мөн Сонгуулийн Ерөнхий Хорооноос гаргасан “Төрийн бус байгууллага сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт, хөндлөнгийн хяналт хийх журам батлах тухай” 2020 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн №23 дугаар тогтоолын хамт хүргүүлэв.

Мониторингод хамрагдсан хороод, хэсгийн хороод, нийт сонгогчдын тоо



2020 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас хэсгийн хороодод хүргүүлсэн Сонгогчдын нэрийн жагсаалтад мониторингийн аргачлалын дагуу хяналт тавихад юуны түрүүнд мэдээлэл өгөхөөс татгалзах, сонгогчдын нэрийн жагсаалттай танилцах бололцоо олгосон ч аргачлалын дагуу нягтлах шаардлагатай сонгогчдын мэдээллийг

ажиглагч зөвхөн цээжилж тогтоохоос өөрөөр авч хянах боломжгүй болгох зэргээр хүндрэл учруулах тохиолдол нэлээд учирсан. Түүнчлэн сонгуульд ажиглалт хийж буй ТББ-ын хувьд сонгогчдын нэрийн жагсаалтын зөвхөн цаасан хувилбартай танилцах боломжтой байгаа нь сонгогч өөр хаяг, эсвэл өөр хэсгийн хороонд давхар бүртгэгдсэн эсэхийг шалгах бололцоог хумьж байна.



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ХУВЬД:

5 дугаар хорооны 22-16, 22-13 дугаар хэсгийн хороод нийт сонгогчдын тоо, “түр хасав” тэмдэглэгээтэй сонгогчдын тоо болон санал өгөх сонгогчдын тоог мэдээлээгүй, сонгогчдын нэрийн жагсаалттай танилцуулахаас татгалзсан.

8-р хорооны 22-22, 12-р хорооны 22-30, 5-р хорооны 22-12, 22-р хорооны 23-44, 23-45 дугаар хэсгийн хороод “түр хасав” төлөвтэй бүртгэгдэн сонгогчдын тоог мөн өгөөгүй.

Хүснэгт 1. БЗД-ийн сонгогчдын нэрийн жагсаалтын мэдээлэл (5 дугаар сарын 27-ны байдлаар)

Хороо	Хэсгийн хороо	Нийт сонгогч	Түр хасав	Санал өгөх иргэдийн тоо
8-р хороо	22-21	2791	251	2540
	22-22	2680	Дүн өгөөгүй	Дүн өгөөгүй
	22-23	2754	219	2535
	22-24	2854	257	2597
	22-25	2806	263	2543
12-р хороо	23-27	2655	203	2452
	23-28	1340	90	1250
	23-29	2467	214	2253
	23-30	2488	Дүн өгөөгүй	Дүн өгөөгүй
5-р хороо	22-12	2817	Дүн өгөөгүй	Дүн өгөөгүй
	22-13	Өгөөгүй	Дүн өгөөгүй	Дүн өгөөгүй
	22-14	2780	213	2567
	22-15	2697	187	2510
	22-16	Дүн өгөөгүй	Дүн өгөөгүй	Дүн өгөөгүй
	22-17	2405	233	2172
22-р хороо	23-43	2256	178	2078
	23-44	2100	Дүн өгөөгүй	Дүн өгөөгүй
	23-45	2570	Дүн өгөөгүй	Дүн өгөөгүй
	23-46	1988	183	1805

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ХУВЬД:

- 7 дугаар хорооны 28-25 дугаар хэсгийн хороо нийт сонгогчдын тоо, “түр хасав” төлөвтэй бүртгэгдсэн сонгогчдын тоо болон санал өгөх сонгогчдын тоог мэдээлээгүй, сонгогчдын нэрийн жагсаалттай танилцуулахаас татгалзсан.

- 22-р хорооны 27-39, 6-р хорооны 27-31 дугаар хэсгийн хороод “түр хасав” тэмдэглэгээтэй сонгогчдын тоог өгөөгүй.

Хүснэгт 2. СХД-ийн сонгогчдын нэрийн жагсаалтын мэдээлэл (5 дугаар сарын 27-ны байдлаар)

Хороо	Хэсгийн хороо	Нийт сонгогч	Түр хасав	Санал өгөх иргэдийн тоо
40	28-19	1763	97	1666
	28-17	1831	126	1705
	28-18	2061	125	1936
41	27-15	2266	98	2168
	27-16	2393	130	2263
24	27-37	2245	132	2113
	27-36	2307	119	2188



Хүснэгт 2-ын үргэлжлэл

Хороо	Хэсгийн хороо	Нийт сонгогч	Түр хасав	Санал өгөх иргэдийн тоо
22	27-39	2457	Дүн өгөөгүй	Дүн өгөөгүй
	27-38	2293	91	2202
	27-40	2417	145	2272
6	27-33	2345	152	2193
	27-32	2162	223	1939
	27-31	2298	Дүн өгөөгүй	Дүн өгөөгүй
7	28-26	1788	141	1647
	28-24	1884	116	1768
	28-25	Дүн өгөөгүй	Дүн өгөөгүй	Дүн өгөөгүй
10	28-34	2334	212	2122
	28-33	2491	175	2316
	28-35	2126	152	1974
39	28-16	2097	144	1953
	28-15	1861	99	1762

2020 оны 6 дугаар сарын 20-ны байдлаар сонгогчдын шилжих хөдөлгөөний мэдээллийг тусган шинэчилсэн сонгогчдын нэрийн жагсаалттай дээрх мэдээллийг харьцуулахад дараах өөрчлөлт орсон байв.

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ХЭСГИЙН ХОРООДОД:

Хүснэгт 3. БЗД-ийн сонгогчдын нэрийн жагсаалтын мэдээлэл (6 дугаар сарын 20-ны байдлаар)

Хороо	Хэсгийн хороо	Нийт сонгогч 5-р сарын 27-ны байдлаар	Нэмэгдсэн (Шилжиж ирсэн)	Түр хасав 6-р сарын 20-ны байдлаар	6-р сарын 20-ны байдлаар нийт сонгогч
8	22-21	2802	11	20	2793
	22-22	Дүн өгөөгүй	9	15	6-р буурсан
	22-23	2762	8	19	2751
	22-24	2873	19	3	2889
	22-25	2819	13	12	2820
12	23-27	2667	12	32	2647
	23-28	1340	13	0	1353
	23-29	2478	11	19	2470
	23-30	Дүн өгөөгүй	10	Эцсийн дүнгээр 223 болсон	0*
5	22-12	2640	14	Эцсийн дүнгээр 191 болсон	0*
	22-13	Дүн өгөөгүй	18	25	7-р буурсан
	22-14	2794	14	25	2783
	22-15	2706	9	5	2710
	22-16	Дүн өгөөгүй	8	20	0*
	22-17	2413	8	24	2397
	23-43	2265	9	15	2259
22	23-44	2110	10	Эцсийн дүнгээр 163 болсон	0*
	23-45	2583	13	Эцсийн дүнгээр 189 болсон	0*
	23-46	1989	14	13	1990

0* нийт сонгогчдын тоог өгөөгүй, түр хасав тэмдэглэгээтэй иргэдийн 5 дугаар сарын 27-ны мэдээлэл байхгүйн улмаас эцсийн тоог гаргах боломжгүй.



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ХЭСГИЙН ХОРООДОД:

Хүснэгт 4. СХД-ийн сонгогчдын нэрийн жагсаалтын мэдээлэл (6 дугаар сарын 20-ны байдлаар)

Хороо	Хэсгийн хороо	Нийт сонгогч 5-р сарын 27-ны байдлаар	Нэмэгдсэн (Шилжиж ирсэн)	Түр хасав 6-р сарын 20-ны байдлаар
40	28-19	1774	11	
	28-17	Дүн өгөөгүй		
	28-18	1924	-137	
41	27-15	2277	11	7
	27-16	2403	10	13
24	27-37	2107	-138	18
	27-36	2184	-123	13
22	27-39	2470	13	
	27-38	2306	13	
	27-40	2428	11	
6	27-33	2358	13	25
	27-32	2166	4	15
	27-31	2313	15	
7	28-26	1795	7	
	28-24	1893	9	10
	28-25	2361		
10	28-34	2348	14	
	28-33	2497	6	
	28-35	2136	10	8
39	28-16	2107	10	
	28-15	1867	6	

Сонгогчдын нэрийн жагсаалттай танилцаж хаяг баталгаажуулахдаа дараах 5 бүлэгт хувааж нягталж шалгав. Үүнд:

1. Бүгд хаяг дээрээ байгаа эсэх;
2. Байнга оршин суудаг хүний тоо;
3. Бүртгэлтэй хэдий ч өөр газар оршин суудаг хүмүүс;
4. Өөр газар амьдардаг ч бүртгэлтэй хүмүүсийг одоогийн амьдарч байгаа хүмүүс нь таних эсэх (урьд нь амьдарч байсан, эсвэл огт тийм хүн амьдардаггүй эсэхийг тодорхойлох);
5. Хашаа, байрандаа анхнаасаа оршин суусан эсэх

Сонгогчдын нэрийн жагсаалтаас авсан 970 сонгогчийн мэдээллийг хаягаар нь очиж нягталж үзэхэд 404 нь бүртгэлтэй хаяг дээрээ янз бүрийн шалтгаанаар байгаагүй. Үүнд

тухайлбал, хаяг дээрээ 23 жил амьдарсан сонгогч тухайн хаяг дээр нь бүртгэлтэй байх сонгогчийг огт танихгүй байх тохиолдол байхаас гадна зарим хаяг дээр байрших байшин, орон гэр нь хүн амьдрах боломжгүй нөхцөлтэй газар байсныг ажиглагчид баримтжуулсан. Хуульд заасны дагуу сонгогчийг байнга оршин суугаа хаягаар нь сонгуулийн зөвхөн нэг хэсэгт бүртгэх учиртай. Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд заасанчлан “Иргэн иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлтэй хаягаас өөр хаягт шилжин 180 хоногоос дээш хугацаагаар оршин суухаар бүртгүүлэхийг байнга [...] оршин суух гэнэ” гэж тогтоосон. Сонгогчдын нэрийн жагсаалтыг үнэн зөв үйлдэхэд хуулийн энэхүү шаардлагыг нэг мөр хангаж ажиллахад анхаарах шаардлагатай байна.



Хүснэгт 5. БЗД-т шалгасан хаягууд

№	Хаяг	Нэрийн жагсаалтад бүртгэлтэй	Хаяг дээрээ амьдарч байгаа	"Түр хасав" төлөвтэй	Урьд нь амьдарч байсан	Мэдэхгүй (Тус хаяг дээрх оршин суугч, хөрш г.м эх сурвалжаас)	Анхнаасаа уг хаяг дээр амьдарсан	Тодорхойлж чадаагүй	Хаягаар нь олоогүй, газарт орсон эсвэл эзгүй байсан	Тайлбар
1	БЗД, 8-р хороо, Эрдэнэтолгой 50 гудамж ххх тоот	10	0	0	0	0	0	0	10	Тус хаяг дээр хүмүүс амьдардаг байх боломжгүй буюу байшин нь балгас болсон байсан
2	БЗД, 5-р хороо, Моносын 1 гудамж ххх тоот	49	49	0	0	0	0	0	0	
3	БЗД, 5-р хороо, Монелийн 12 гудамж ххх тоот	20	2	2	0	0	0	16	0	
4	БЗД, 5-р хороо, Монелийн 1 гудамж ххх тоот	6	2	0	4	0	0	0	0	
5	БЗД, 5-р хороо, 19 гудамж ххх тоот	10	2	0	7	0	0	1	0	
6	БЗД, 22-р хороо, Өлгий 12 гудамж ххх тоот	2	2	0	0	0	0	0	0	Сонгогчдын нэрийн жагсаалтад ижил овог, ижил нэртэй хүмүүс бүртгэлтэй байсан хэдий ч төрсөн он нь өөр буюу 1972, 2002 оных байсан
7	БЗД, 8-р хороо, УС-15 ххх тоот	2	0	0	0	0	0	0	2	
8	БЗД, 5р хороо, Монелийн 17р гудамж, ххх тоот	14	0	0	0	0	0	0	14	
9	БЗД, 22р хороо, Өлгий 15р гудамж ххх тоот	2	0	0	0	0	0	0	2	Анимаа, Аминаа гэдэг ойролцоо нэртэй хүмүүс бүртгэлтэй.



Хүснэгт 6. СХД-т шалгасан хаягууд

№	Хаяг	Нэрийн жагсаалтад бүртгэлтэй	Хаяг дээрээ амьдарч байгаа	"Тур хасав" төлөвтэй	Урьд нь амьдарч байсан	Мэдэхгүй (Тус хаяг дээрх оршин суугч, хөрш г.м эх сурвалжаас)	Анхнаасаа уг хаяг дээр амьдарсан	Тодорхойлж чадаагүй	Хаягаар нь олоогүй, газарт орсон эсвэл эзгүй байсан	Тайлбар
1	СХД, 40-р хороо, Баянхошууны 34-р гудамж, ххх тоот	13	5	5	0	0	0	3	0	
2	СХД, 40-р хороо, Мон лаа 2-р гудамж, ххх тоот	5	0	3	0	0	0	0	2	
3	СХД, 40-р хороо, Мон лаа 3-р гудамж ххх тоот	6	0	4	0	0	0	0	2	
4	СХД, 40-р хороо, Баянхошууны 30-р гудамж, ххх тоот	3	0	3	0	0	0	0	0	
5	СХД, 40-р хороо, Баянхошуу 32-р гудамжны 47 тоот	9	0	0	0	0	0	0	9	47а, 47б гэж байсан хэр нь 47 гэж олдоогүй
6	СХД, 41-р хороо, зээлийн 2-р гудамж, ххх тоот	2	2	0	0	0	0	0	0	Б.Ганчимэг, Ч.Ганчимэг хамаатны хүмүүс амьдардаг.
7	СХД, 41-р хороо, зээлийн 3-р гудамж, ххх тоот	10	6	0	0	0	0	4	0	
8	СХД, 41-р хороо, зээлийн 9-р гудамж, ххх тоот	16	16	0	0	0	0	0	0	
9	СХД, 41-р хороо, зээлийн 6-р гудамжны ххх тоот	11	0	0	0	0	0	0	11	Энэ хаяг дээр Буянжаргал нэртэй 2 сонгогч бүртгэлтэй тул шалгах нь зүйтэй гэж үзсэн.
10	СХД, 41-р хороо, зээлийн ххх тоот	9	7	0	0	0	0	2	0	
11	СХД, 41-р хороо, Зээлийн 11-р гудамж, ххх тоот	8	4	0	4	0	0	0	0	
12	СХД, 41-р хороо, Зээлийн 12-р гудамж, ххх тоот	9	5	0	4	0	0	0	0	
13	СХД, 41-р хороо, Зээлийн 12-р гудамж, ххх тоот	9	7	0	0	0	0	2	0	
14	СХД, 41-р хороо, Зээлийн 12-р гудамж, ххх тоот	8	2	2	4	0	0	0	0	
15	СХД, 41-р хороо, Зээлийн 14-р гудамж, ххх тоот	11	2	0	9	0	0	0	0	



№	Хаяг	Нэрийн жагсаалтад бүртгэлтэй	Хаяг дээрээ амьдарч байгаа	"Тур хасав" төлөвтэй	Урьд нь амьдарч байсан	Мэдэхгүй (Тус хаяг дээрх оршин суугч, хөрш г.м эх сурвалжаас)	Анхнаасаа уг хаяг дээр амьдарсан	Тодорхойлж чадаагүй	Хаягаар нь олоогүй, газарт орсон эсвэл эзгүй байсан	Тайлбар
16	СХД, 41-р хороо, Зээлийн 14-р гудамж, ххх тоот	12	2	0	0	0	0	10	0	Тус хаяг дээр хүн амьдардаг шинжгүй хэдий ч хөрш айлаас тодруулахад 2 хүн нь энд байдаг гэсэн хариу өгсөн.
17	СХД, 41-р хороо, Зээлийн 14-р гудамж, ххх тоот	7	6	0	1	0	0	0	0	Тус хаяг дээр 6 иргэн нь оршин суудаг. 1 хүн өөр хаяг руу шилжсэн ч шилжүүлгээ хийлгээгүй байгаа.
18	СХД, 41-р хороо, Зээлийн 15-р гудамж, ххх тоот	8	4	0	0	4	0	4	0	Амьдарч буй хүмүүс нь 4 хүний талаар мэдэхгүй гэсэн.
19	СХД, 41-р хороо, Зээлийн 15-р гудамж, ххх тоот	7	7	0	0	0	0	0	0	
20	СХД, 41-р хороо, Зээлийн 16-р гудамж, ххх тоот	10	6	1	0	0	0	3	0	
21	СХД, 41-р хороо, Зээлийн 16-р гудамж, ххх тоот	12	6	0	6	0	0	0	0	
22	СХД, 41-р хороо, Зээлийн 16-р гудамж, ххх тоот	8	8	0	0	0	0	0	0	
23	СХД, 41-р хороо, Зээлийн 16-р гудамж, ххх тоот	9	5	0	4	0	0	0	0	
24	СХД, 41-р хороо, Зээлийн 16-р гудамж, ххх тоот	12	12	0	0	0	0	0	0	
25	СХД, 41-р хороо, Зээлийн 16р гудамж, ххх тоот	8	7	0	0	0	0	1	0	Ижил нэртэй, овог өөр 2 Янжинлхам амьдардаг.
26	СХД, 41-р хороо, Зээлийн 17-р гудамж, ххх тоот	9	5	0	0	4	5	0	0	Энэ хаяг дээрээ 20 гаран жил болж байгаа, 4 хүнийг мэдэхгүй.
27	СХД, 41-р хороо, Зээлийн 17-р гудамж, ххх тоот	15	6	2	7	0	0	0	0	Дэлхийн зөн байгууллагаас 4 айлд хувааж өгсөн газар.
28	СХД, 41-р хороо, Зээлийн 18-р гудамж, ххх тоот	8	8	0	0	0	0	0	0	
29	СХД, 41-р хороо, Зээлийн 18-р гудамж, ххх тоот	4	0	4	0	0	0	0	0	Японоос ирээд хөл хорионд орсон.



Хүснэгт 6-гийн үргэлжлэл

№	Хаяг	Нэрийн жагсаалтад бүртгэлтэй	Хаяг дээрээ амьдарч байгаа	"Түр хасав" төлөвтэй	Урьд нь амьдарч байсан	Мэдэхгүй (Тус хаяг дээрх оршин суугч, хөрш г.м эх сурвалжаас)	Анхнаасаа уг хаяг дээр амьдарсан	Тодорхойлж чадаагүй	Хаягаар нь олоогүй, газарт орсон эсвэл эзгүй байсан	Тайлбар
30	СХД, 41-р хороо, Зээлийн 20-р гудамж, ххх тоот	9	0	3	0	0	0	0	9	
31	СХД, 41-р хороо, Зээлийн 21-р гудамж, ххх тоот	10	0	0	0	0	0	0	10	
32	СХД, 41-р хороо, Зээлийн 21-р гудамж, ххх тоот	10	7	0	3	0	0	0	0	
33	СХД, 41-р хороо, Зээлийн 24-р гудамж, ххх тоот	12	0	0	0	0	0	0	12	
34	СХД, 24-р хороо, Зээлийн 33-р гудамж, ххх тоот	10	5	0	0	0	0	5	0	
35	СХД, 24-р хороо, хустайн 1-р гудамж, ххх тоот	10	4	0	0	0	0	6	0	
36	СХД, 24-р хороо, хустайн 1в гудамж, ххх тоот	9	9	0	0	0	0	0	0	
37	СХД, 24-р хороо, хустайн 4 гудамж, ххх тоот	10	3	0	7	0	0	0	0	
38	СХД, 24-р хороо, зээлийн 37-р гудамж ххх тоот	9	7	0	2	0	0	0	0	
39	СХД, 24-р хороо, зээлийн 37-р гудамж ххх тоот	5	0	0	0	0	0	0	5	Ижил нэртэй, овог өөр 2 Батцэцэг амьдардаг.
40	СХД, 24-р хороо, Зээлийн 38-р гудамж, ххх тоот	10	0	0	0	0	0	0	10	
41	СХД, 22-р хороо, Хилчин 76-р гудамж ххх тоот	2	0	0	0	0	0	0	2	Ижил нэртэй, овог өөр 2 Энхцэцэг амьдардаг.
42	СХД, 22-р хороо, Хилчин 44-р гудамж ххх тоот	12	1	0	0	0	11	0	0	
43	СХД, 22-р хороо, Хилчин 24-р гудамж ххх тоот	11	2	0	3	0	6	0	0	
44	СХД, 6-р хороо, Тоосгоны 24 гудамж ххх тоот	2	1	1	0	0	0	0	0	Ижил нэртэй, овог өөр 2 Алтанцэцэг.
45	СХД, 39-р хороо, Хангайн 36-р гудамж ххх тоот	15	15	0	0	0	0	0	0	
46	СХД, 39-р хороо, Хангайн 56 гудамж ххх тоот	13	0	0	0	0	0	0	13	
47	СХД, 39-р хороо, Хангайн 45 гудамж ххх тоот	4	0	4	0	0	0	0	4	



№	Хаяг	Нэрийн жагсаалтад бүртгэлтэй	Хаяг дээрээ амьдарч байгаа	"Тур хасав" төлөвтэй	Урьд нь амьдарч байсан	Мэдэхгүй (Тус хаяг дээрх оршин суугч, хөрш г.м эх сурвалжаас)	Анхнаасаа уг хаяг дээр амьдарсан	Тодорхойлж чадаагүй	Хаягаар нь олоогүй, газарт орсон эсвэл эзгүй байсан	Тайлбар
48	СХД, 39-р хороо, хангайн 59 гудамж ххх тоот	17	10	4	3	0	0	0	0	
49	СХД, 39-р хороо, Хангайн 66 гудамж ххх тоот	2	0	0	0	0	0	2	0	Өлзийбаярын Нандинсүвд, Нандин-эрдэнэ ихрүүд нэг хаяг дээр амьдардаг хэдий ч Сонгогчдын нэрийн жагсаалтад хаягийг 06, 6 гэж өөрөөр бүртгэсэн байсан.
50	СХД, 6-р хороо, ХМК 69 гудамж ххх тоот	145	145	0	0	0	0	0	0	Халамжийн төвийн ажилтны хэлснээр энд бүртгэлтэй хүмүүсийн 30-40 хувь нь л сонгуульд санал өгдөг.
51	СХД, 6-р хороо, 58г байр ххх тоот	7	0	0	0	0	0	0	7	Иргэнээс тус хаяг дээрх сонгогчдын бүртгэлийг нягтлах хүсэлт тавьсан. Очиход эзгүй байсан.

ГУРАВДАГЧ ЭХ ҮҮСВЭРЭЭС АВСАН СОНГОГЧИЙН БҮРТГЭЛТЭЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЛИЙГ НЯГТАЛЖ ШАЛГАСАН ДҮН

Иргэд, нэр дэвшигчдээс ирсэн сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой гомдол, хүсэлт болон хэвлэлээс авсан мэдээллийг дагуу ажиглагчид дараах хаягуудаар очиж мэдээллийг нягталсан.

- Иргэн Тэмүүлэнгийн ирүүлсэн хүсэлтийн дагуу СХД-ийн 6-р хорооны 58г байрны ххх тоотын 7 хүний мэдээллийг нягтлахаар очиход тухайн айл эзгүй байсан.
- Чингэлтэй дүүрэг 25 дугаар тойрогт Бие даан нэр дэвшигч Д.Анхбаяр Тагнуулын Ерөнхий Газрын гадаа 2020 оны 6 дугаар сарын 17-ны өдөр өгсөн ярилцлагад

дурдсан Баянзүрх дүүргийн 2-р хорооны 2-р хэсгийн Их дарь эхийн 1-р гудамж, ххх тоотын 46 хүний мэдээллийг шалгахад 31 хүн нь амьдардаг байв. Нэг хаяг дээр олон хүн бүртгэсэн нь 2016 онд тухайн үед ажиллаж байсан 2-р хорооны засаг дарга задгай хаягуудыг нэг хаяг болгон бүртгэснээс үүдсэн байлаа. Ийм задгай дээр оршин суудаг хэр нь 100 тоот хэмээн албан ёсны бүртгэлтэй, байршлын хувьд 3 хэсэг газар байрлах хашаанууд 2016 оны байдлаар байсан бөгөөд 2020 онд тухайн хаяг дээр газрын гэрчилгээгээ албан ёсоор авсан нь нэг айл байв.



Хүснэгт 7. Нэр дэвшигч Анхбаярын дурдсан мэдээллийг нягталж хянасан дүн

№	Хаяг	Нэрийн жагсаалтад бүртгэлтэй								Тайлбар
		Хаяг дээрээ амьдарч байгаа	"Түр хасав" төлөвтэй	Урьд нь амьдарч байсан	Мэдэхгүй (Тус хаяг дээрх оршин суугч, хөрш г.м эх сурвалжаас)	Анхнаасаа уг хаяг дээр амьдарсан	Тодорхойлж чадаагүй	Хаягаар нь олоогүй, газарт орсон эсвэл эзгүй байсан		
1	БЗД, 2-р хороо, их дарь эх 3 гудамж ххх тоот	46	31	2	0	13	0	0	0	Тус хаяг нь задгай бөгөөд 3 хэсэгт хуваагдсан хашаанууд байв. Сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэлтэй 40 иргэний мэдээллийг баталгаажуулав. Замын нөхцөл байдлаас шалтгаалан 6 хүний мэдээллийг нягталж чадаагүй.

- Монгол Ардын намаас Сүхбаатар дүүргийн сонгогчдын нэрийн жагсаалтаас түүвэрлэн шалгуулахаар доорх иргэдийн мэдээллийг өгсөн. Үүнд:


Хүснэгт 8. Монгол Ардын намаас ирүүлсэн мэдээллийг нягталж хянасан дүн

№	Хаяг	Нэрийн жагсаалтад бүртгэлтэй								Тайлбар
		Хаяг дээрээ амьдарч байгаа	"Түр хасав" төлөвтэй	Урьд нь амьдарч байсан	Мэдэхгүй (Тус хаяг дээрх оршин суугч, хөрш г.м эх сурвалжаас)	Анхнаасаа уг хаяг дээр амьдарсан	Тодорхойлж чадаагүй	Хаягаар нь олоогүй, газарт орсон эсвэл эзгүй байсан		
1	УБ, Сүхбаатар, 9-р хороо алтайн 15 гудамж ххх тоот	26	0	5	0	0	0	0	26	
2	УБ, Сүхбаатар, 9-р хороо алтайн 5 гудамж ххх тоот	24	22	1	0	1	0	0	0	Оршин суугчид нь хаяг дээрээ 23 жил амьдарсан ба Болор-Эрдэнэ гэдэг хүнийг огт танихгүй гэсэн буюу хаяг дээр нь огт танихгүй 1 хүн бүртгэлтэй байсан тухай оршин суугч нь хэлсэн.
3	УБ, Сүхбаатар, 9-р хороо алтайн 5 гудамж ххх тоот	23	0	3	0	0	0	0	23	
4	УБ, Сүхбаатар, 9-р хороо алтайн 8 гудамж ххх тоот	17	16	1	0	0	0	0	0	



№	Хаяг	Тайлбар							
		Нэрийн жагсаалтад бүртгэлтэй	Хаяг дээрээ амьдарч байгаа	"Тур хасав" төлөвтэй	Урьд нь амьдарч байсан	Мэдэхгүй (Тус хаяг дээрх оршин суугч, хөрш г.м.э сурвалжаас)	Анхнаасаа уг хаяг дээр амьдарсан	Тодорхойлж чадаагүй	Хаягаар нь олоогүй, газарт орсон эсвэл эзгүй байсан
5	УБ, Сүхбаатар, 9-р хороо нуурын 7 гудамж ххх тоот	19	0	0	0	0	0	0	19
6	УБ, Сүхбаатар, 9-р хороо нуурын 8 гудамж ххх тоот	20	0	7	0	0	0	0	20
7	УБ, Сүхбаатар, 9-р хороо алтайн 7 гудамж ххх тоот	19	19	0	0	0	0	0	0
8	УБ, Сүхбаатар, 12-р хороо хангайн 23 гудамж ххх тоот	23	3	3	0	17	0	0	0
9	УБ, Сүхбаатар, 12-р хороо хангайн 1 гудамж ххх тоот	22	4	0	12	6	0	0	0
10	УБ, Сүхбаатар, 13-р хороо ногоон талбай 7 гудамж ххх тоот	21	7	0	14	0	0	0	0

Хаягаар баталгаажуулалт хийсэн дүн (Дүүргээр)





Сонгуулийн өдөр санал хураах байруудад ажиглалт хийсэн иргэний нийгмийн ажиглагчдын тайланд Сонгуулийн өдөр хурууны хээ уншигч сонгогчдын хурууны хээг танихгүй, улмаар сонгогчийг регистрийн

дугаараар нь бүртгэх тохиолдол нэлээд гарсан, түүнчлэн хурууны хээг уншуулахад өөр хүний зураг гарч ирэх тохиолдлууд мөн байсныг дурджээ.

Ажиглагчдын бүртгэсэн нэг жишээг дурдахад:

№	Хаяг	Овог нэр	Регистрийн дугаар (эсвэл нас)	Сонгуулийн хэсгийн хороо	Хаягаар нь очиж баталгаажуулсан эсэх
1	УБ, Баянзүрх дүүрэг, 13-р хороо Энхтайваны өргөн чөлөө 89-103 тоот	Намхайн Чулуунпүрэв	МЮ 6304XXXX	22-28	Санал өгөхөөр сонгуулийн хэсгийн хороонд иргэний үнэмлэхтэйгээ ирсэн ба төхөөрөмж хурууны хээ уншихгүй байсан. Улсын бүртгэлийн ажилтан регистрийн дугаарыг програмд оруулах үед өөр хүний зураг гарч ирсэн. Иймд тус иргэнийг санал өгүүлээгүй. Дараа нь тус иргэний эхнэр нь сонгуулийн хэсгийн хороон дээр ирж Н.Чулуунпүрэв нь тус хэсэгт санал өгөх ёстой талаар хэлсэн. Улсын бүртгэлийн ажилтан үнэмлэхний лавлагааг авчруулж, ажиглагч нараас санал асууж, тус иргэний саналыг өгүүлсэн болно. Холбогдох зургуудыг хавсаргав.

ЗӨВЛӨМЖ

ХУУЛЬ ТОГТООГЧДОД:

Хууль болон СЕХ-ноос гаргасан шаардлагыг ханган сонгуулийн үйл явцад хөндлөнгийн хяналт, ажиглалт хийж буй ТББ-уудад нам, эвслийн нэгэн адил хүсэлт гарган сонгогчдын нэрийн жагсаалтын хуулбарыг цахим байдлаар авч хяналт тавих бололцоог нээх.

Улс төрийн намуудад:

- Хуульд заасан хугацаандаа багтаж сонгогчдын нэрийн жагсаалтын хуулбарыг авч нягтлан шалгах ажлыг өргөн хүрээнд идэвхтэй зохион байгуулах;
- Сонгогчдын нэрийн жагсаалттай танилцаж, хяналт хийх дараах аргачлалын талаар нэр дэвшигчдэдээ танилцуулж, мэдээллээр хангах.

Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий Хороонд:

Сонгуулийн Ерөнхий Хорооноос баталсан “Төрийн бус байгууллага сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт, хөндлөнгийн хяналт хийх журам батлах тухай” 2020 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн №23 дугаар тогтоол, түүний хавсралтаар олгогдсон “Төрийн бус байгууллага сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт, хөндлөнгийн хяналт хийх журам”-ын 3.1.2 дугаар зүйлд заасан сонгогчдын нэрийн жагсаалттай танилцах эрхтэй гэсний “танилцах” гэдэг хяналт тавих боломжийг хумьж, сонгуулийн үйл явцын ил тод байдлыг хангахад хувь нэмрээ оруулан ажиллаж буй иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаанд саад учруулж буйг анхаарах нь чухал байна. Сонгогчдын



нэрийн жагсаалтаас зайлшгүй шалгаж нягтлах ёстой гэж үзсэн мэдээллээ тэмдэглэж, хуулбарлаж авах боломжоор хангах нь цаашид сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой гарч буй маргаан, аливаа эргэлзээг тайлж оролцогч талуудын итгэлийг нэмэгдүүлэхэд чухал нөлөөтэй болно. Үүнтэй холбоотойгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнд:

- Сонгуулийн ерөнхий хорооны тогтоолд төрийн бус байгууллагуудын эрх үүргийг илүү тодорхой тусгах. Жишээ нь: Сонгогчдын нэрийн жагсаалттай танилцахаас гадна нэмэлтээр тэмдэглэл хийх, бусад тоо баримтыг (шилжилт хөдөлгөөний тоо баримтууд) сонгуулийн хэсгийн хороодоос авах эрхээр хангах талаар тусгах;
- Сонгогчдын нэрийн жагсаалт 5 дугаар сарын 27-нд хэсгийн хороодод хүргүүлж байхад сонгуулийн үйл явцад хөндлөнгийн хяналт, ажиглалт хийх төрийн бус байгууллагуудыг бүртгэсэн шийдвэр 6 дугаар сарын 1-нд гарсан нь цаг хугацааны хувьд хяналтын ажлыг хойш татсаныг анхаарч, ТББ-уудыг бүртгэх асуудлыг шуурхай шийддэг болох;
- Сонгуульд хөндлөнгийн хяналт тавих ТББ-уудыг бүртгэж авсан тогтоол шийдвэрийг аймаг, дүүргийн сонгуулийн хороодод мэдээлэх. Ингэснээр аймаг, дүүргийн хороод, цаашлаад сонгуулийн хэсгийн хороодод мэдээлэл шуурхай хүрч, хөндлөнгийн хяналт хийж буй ТББ-уудын хувьд цаг хугацаа хэмнэх, ажлаа саад бэрхшээлгүй урагшлуулах нөхцөл бүрдэнэ.

Улсын Бүртгэлийн Ерөнхий газарт:

- Burtgel.gov.mn сайтаас сонгогч өөрийн санал өгөх хэсгийн хороогоо харахаас гадна тухайн гэрийн хаяг дээр нь нийт хэдэн хүн бүртгэлтэй байгаа тоог харах боломжтой болгох;

- Регистрийн дугаарын сондгой тоо-эрэгтэй, тэгш тоо-эмэгтэй байдаг ба иргэдэд регистрийн сүүлийн 2 орон буруу олгогдсон тохиолдлууд байсаар байгааг анхаарч засах арга хэмжээ авах;
- Сонгуулийн өдөр иргэдийн хурууны хээг төхөөрөмж уншихгүй байх тохиолдол нэлээд гарч буйг анхаарч зохих арга хэмжээ авах;
- Хурууны хээгээ уншуулахад иргэний бүртгэлийн систем дээр өөр хүний мэдээлэл гарч ирсэн тохиолдол гарсан ба цаашид ийм алдаа гаргахгүй байх арга хэмжээ авч шалгаж, залруулах;
- Иргэний шилжилт хөдөлгөөн, “Түр хасав” төлөвтэй бүртгэгдсэн байгаа сонгогчдын тоо, холбогдох мэдээллийг сонгуулийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хийж буй эрх бүхий байгууллагуудад нээлттэй мэдээлж, сонгуулийн үйл явцын ил тод байдлыг хангах;
- Байнгын оршин суух хаягаар сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэх хуулийн шаардлагыг мөрдлөг болгож хаягийн зөрчлийг арилгах арга хэмжээ авах (тодорхой хаяг дээр байнга оршин сууж буй иргэдийн хүсэлтээр шилжсэн буюу тухайн хаяг дээр амьдардаггүй иргэдийн мэдээллийг сонгогчдын нэрийн жагсаалтаас хасах арга хэмжээ авах).

Улаанбаатар хотын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд:

- Гэр хорооллын хаягжилтыг нэг стандартын дагуу болгож цэгцлэх;
- Гудамжны нэр, дугаар, тоотыг ойлгомжтой, дэс дараалалтай болгох;
- Задгай хаягуудыг бүртгэлжүүлэх нэгдсэн аргачлалтай болох;
- Хорооны газрын зургуудыг цахим хуудсандаа байршуулах.



ХАВСРАЛТ

Хавсралт-1

Сонгогчдын нэрийн жагсаалтад нэг хаяг дээр ижил овог, нэртэй боловч регистрийн дугаар нь өөр хоёр сонгогчийг бүртгэсэн жишээ (2017 онд мэдээллийг баримтжуулсан нь)

ТА ХУВИЙН МЭДЭЭЛЛЭЭ ҮНЭН ЗӨВ ЭСЭХИЙГ ШАЛГАНА УУ.

Регистрийн дугаар : УС85032103
 Эцэг/эх/-ийн нэр : УРАНЧИМЭГ
 Өөрийн нэр : АМАРЖАРГАЛ
 Нас : 32
 Хүйс : ЭМЭГТЭЙ
 Хаяг : УБ, Баянзүрх, 22-р хороо алтан өлгий 19 гудамж 274 тоот
 Төлев : ҮНДСЭН ХАЯГАН ДЭЭРЭЭ БАЙГАА

ХЭРЭВ ТА ТҮР ХАСАВ ТӨЛӨВТЭЙ БАЙГАА БОЛ

Сонгуулийн тухай хуулийн 61.9, 64.4 дэх заалтыг үзнэ үү.

Сонгуулийн тойрог : 1
 Сонгуулийн хэсэг : 1720
 Санал өгөх байр : 22-Р ХОРООНЫ ЦОГЦОЛБОР БАЙРАНД

Хавсралт-2

Баянзүрх дүүргийн 22-р хорооноос авсан тодорхойлолт

Баянзүрх дүүргийн
 Д.Д. ДУГААР ХОРОО
 2018 он 06 сар 15 өдөр
 № 1650

ТОДОРХОЙЛОЛТ

... ТООТ ҮНЭМЛЭХТЭЙ
 Чрпаниа овогтой Амартарга нь
 ... ам бүл
 Антан өлгий 19-274 тоот оршин суудаг
 (Бүртгэлийг оршин суудаггүй)
 Тус халт нь Амартарга
 бүртгэлийг, оршин суудаг 84!!
 -тай болохыг тодорхойлов.

Засаг дарга С.Б. Д. Нарантгарга

ТА ХУВИЙН МЭДЭЭЛЛЭЭ ҮНЭН ЗӨВ ЭСЭХИЙГ ШАЛГАНА УУ.

Регистрийн дугаар : ЖИ85032111
 Эцэг/эх/-ийн нэр : УРАНЧИМЭГ
 Өөрийн нэр : АМАРЖАРГАЛ
 Нас : 32
 Хүйс : ЭРЭГТЭЙ
 Хаяг : УБ, Баянзүрх, 22-р хороо алтан өлгий 19 гудамж 274 тоот
 Төлев : ҮНДСЭН ХАЯГАН ДЭЭРЭЭ БАЙГАА

ХЭРЭВ ТА ТҮР ХАСАВ ТӨЛӨВТЭЙ БАЙГАА БОЛ

Сонгуулийн тухай хуулийн 61.9, 64.4 дэх заалтыг үзнэ үү.

Сонгуулийн тойрог : 1
 Сонгуулийн хэсэг : 1720
 Санал өгөх байр : 22-Р ХОРООНЫ ЦОГЦОЛБОР БАЙРАНД

Хавсралт-3

2020 оны 5 дугаар сарын 14-ний байдлаар burtgel.gov.mn сайтаар сонгогчийн мэдээлэл шалгасан байдал

МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН | Улсын бүртгэлийн ерөнхий газар | Улсын бүртгэлийн ерөнхий газар

on.burtgel.gov.mn/query

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
 УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ТА ХУВИЙН МЭДЭЭЛЛЭЭ ҮНЭН ЗӨВ ЭСЭХИЙГ ШАЛГАНА УУ.

Тохирох мэдээлэл олдсонгүй.
 Бичвэл

Хайлтын огноо: 2020-05-14 18:03:43

УС85032103 Уранчимэгийн Амаржаргалын мэдээлэл олдоогүй.



ТА ХУВИЙН МЭДЭЭЛЛЭЭ ҮНЭН ЗӨВ ЭСЭХИЙГ ШАЛГАНА УУ.

Эцэг/эх/-ийн нэр : УРАНЧИМЭГ
 Өөрийн нэр : АМАРЖАРГАЛ
 Регистрийн дугаар : ЖИ85032111
 Нас : 35
 Хүйс : ЭР
 Хаяг : Улаанбаатар, Баянзүрх 22-р хороо, алтан өлгий 19 гудамж, 274 тоот
 Төлев : ҮНДСЭН ХАЯГАН ДЭЭРЭЭ БАЙГАА

ХЭРЭВ ТА ТҮР ХАСАВ ТӨЛӨВТЭЙ БАЙГАА БОЛ
 УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 20.6 дахь заалтыг үзнэ үү.

Хэсгийн дугаар : 23-44
 Санал өгөх байр : 22-Р ХОРООНЫ БАЙР

ЖИ85032111 Уранчимэгийн Амаржаргал уг хаяг дээр бүртгэлтэй хэвээрээ байна

Хавсралт-4

2020 оны 6 дугаар сарын 2-ны байдлаар burtgel.gov.mn сайтаар сонгогчийн мэдээлэл шалгасан байдал

ТА ХУВИЙН МЭДЭЭЛЛЭЭ ҮНЭН ЗӨВ ЭСЭХИЙГ ШАЛГАНА УУ.

Тохирох мэдээлэл олдсонгүй.

Буцах

Хайлтын огноо: 2020-06-02 14:15:16

УС85032103 Уранчимэгийн Амаржаргалын мэдээлэл олдоогүй хэвээрээ байна

ТА ХУВИЙН МЭДЭЭЛЛЭЭ ҮНЭН ЗӨВ ЭСЭХИЙГ ШАЛГАНА УУ.

Эцэг/эх/-ийн нэр : УРАНЧИМЭГ
 Өөрийн нэр : АМАРЖАРГАЛ
 Регистрийн дугаар : ЖИ85032111
 Нас : 35
 Хүйс : ЭР
 Хаяг : Улаанбаатар, Баянзүрх 22-р хороо, алтан өлгий 19 гудамж, 274 тоот
 Төлев : СОНГУУЛИЙН ХУУЛИЙН 20.6.3 ЗААЛТЫГ ҮНДСЭЛЭН ТҮР ХАСАВ

ХЭРЭВ ТА ТҮР ХАСАВ ТӨЛӨВТЭЙ БАЙГАА БОЛ
 УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 20.6 дахь заалтыг үзнэ үү.

Хэсгийн дугаар : 23-44
 Санал өгөх байр : 22-Р ХОРООНЫ БАЙР

ХЭРЭВ ТАНЫ МЭДЭЭЛЭЛ

Зөв бол баталгаажуулах | Зөрүүтэй бол мэдээлэх

Хэрэв Таны мэдээлэл зөрүүтэй бол Байнга оршин суугаа хаягийн дагуу бүртгэлийн нэгжтэй холбоо барина уу.

Буцах

Хайлтын хугацаа: (1.3260 сек)

Хайлтын огноо: 2020-06-02 14:17:19

Энэхүү сонгогчийн бүртгэлийн талаар УБЕГ-ын дэд даргын 2020 оны 6 дугаар сарын 17-ны 19:00 цагийн Eagle ТВ-ийн мэдээнд өгсөн ярилцлагад УС85032103 регистрийн дугаарыг өөрчлөөд ЖИ85032111 дугаартай болгосон гэж тайлбарласан. Гэтэл 2017 оны УБЕГ-ын вэб хуудсанд тус 2 регистрийн дугаар идэвхтэй буюу хайлтаар гарч ирж байсан. Мөн регистрийн дугаарыг өөрчлөх үед “УС” гэсэн эхний 2 үсэг яагаад “ЖИ” болж өөрчлөгдсөн нь ойлгомжгүй байв.

МОНИТОРИНГИЙН БАГ

Багийн ахлагч: С.Энхжаргал
 Зохион байгуулагч: Б.Цогбаяр
 Судлаачид: П.Жавхлан
 А.Батсуурь
 Б.Дулмаа
 Д.Надмид
 Г.Бат-Учрал
 Б.Мягмардорж



“МИДАС” ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн
 9-р хороо, Их тойруугийн гудамж 7-р
 хорооллын 54-7029 тоот

Уг тайланд туссан хөндлөнгийн дүгнэлт, үзэл бодол нь Нээлттэй Нийгэм Форумын байр суурийг илэрхийлэхгүй болно.